

СЭТГҮҮЛЧИЙН УР ЧАДВАРЫН ТУХАЙД

Д. Гэрэлцэцэг*

* МУИС-ийн Сэтгүүл зүйн тэнхмийн магистрант

Түлхүүр үг: ур чадвар, бичлэгийн төрөл зүйл, мэдээ, сурвалжлага, ярилцлага, өгүүлэл.

ОНМХ нь нийгмийн сэтгэл санаа, ухамсарт тодорхой хэмжээгээр нөлөөлж, тэдний бодол санааг өөрчилж чаддагаараа бусад салбараас ялгарч байдаг. Өөрөөр хэлбэл, нийгмийн удирдлагын хүчтэй хэрэгслүүдийн тоонд ордог. Тийм учраас тухайн ХМХ-д ажиллаж буй сэтгүүлч болон бусад ажилтнууд үр нөлөө сайтай чадварлаг нийтлэл, нийтлэл нэвтрүүлгийг бүтээж олон түмэнд хүргэснээр нийгмийн ухамсарт нөлөөлөх чадвар нь өндөр байдаг. Сэтгүүлч үр нөлөө сайтай, сонирхолтой сайн нийтлэл бичиж чадвал уншигч, сэтгүүлч хоёрын хооронд амьд холбоо үүсч чаддаг. Үр нөлөө муутай, хэнд ч ашиггүй, сонирхолгүй, үлбэгэр нийтлэл бичих нь тухайн сэтгүүлчийн ур чадвар ямар төвшинд байгааг харуулж буйн илэрхийлэл юм. Нийтлэл, нэвтрүүлгийн үр нөлөө ямар байх нь сэтгүүлчийн нийтлэлээ бүтээх ур чадвараас шууд хамаарч байдаг. Тийм учраас сэтгүүлчийн ур чадвар сэтгүүл зүйн онол практик, арга зүйн томоохон асуудлын нэг болдог юм. Сэтгүүл зүйд ур чадвараас ангид зүйл гэж огт

байхгүй. Тиймээс ур чадвар гэдэг нь хэвлэл мэдээллийн байгууллагад ажиллаж байгаа сэтгүүлчдээс гадна бүх мэргэжлийн хүмүүст болон ОНМХ-д нийтэлж, нэвтрүүлж буй ямар ч бичлэгийн төрөл, зүйлд хамаардаг өргөн утга агуулга бүхий асуудал юм.

Нийтлэл нэвтрүүлгийг өндөр төвшинд бэлтгэнэ гэдэг нь янз бүрийн мэргэжлийн хүмүүсийн ур чадварын нэгдлээс бүрддэг онцлогтой. Тухайлбал, телевизийн нэвтрүүлгийг бүтээнэ гэдэг бол сэтгүүлчийн ур чадвараас гадна редактор, оператор, найруулагч, хөтлөгч зэрэг тухайн нэвтрүүлгийг бүтээж буй бүх хүмүүсийн ур чадварын нэгдэл байдаг. Тэр дундаа сэтгүүлчийн ур чадвар голлох үүрэг гүйцэтгэдэг.

Сэтгүүл зүйн онол сэтгүүлчийн ур чадварыг өргөн ба явцуу утгаар тодорхойлдог. Үүнд:

- Ур чадвар гэдэг нь өргөн утгаараа сэтгүүлчийн сэдвээ сонгохоос эхлээд уран бүтээлээ туурвих хүртэлх бүх дамжлага, мөн ОНМХ-д гаргах хүртэлх бүх үе шатыг хамардаг амьд хөдөлгөөнтэй уран бүтээлийн үйл явц мөн. Нөгөө талаар үгийн урлагийн бүх онцлог шинж, элементүүдийг эзэмших үйл явцыг хэлнэ. Сэтгүүлч хүн бол ямагт үгийн ертөнцөд амьдарч байдаг учир түүнийг үйл ажиллагаандаа

чадварлагаар зэвсэг болгон ашиглаж байх ёстой. Чадварлагаар зэвсэг болгон гэдэг бол хий дэмий гоёж чамирхана гэсэн үг огт биш. Харин товч тодорхой, энгийн, шаардлагатай үед хурц тод үг хэллэгийг ашиглан бичнэ гэсэн үг юм.

- Явцуу утгаараа ур чадвар гэдэг сонгосон сэдвийг сэтгүүл зүйн онол, практик, арга зүйн бүх шалгууруудад нийцүүлэн агуулга хэлбэрийн өндөр төвшинд бүтээх үйл ажиллагаа мөн. Тиймээс ч агуулга хэлбэрийн нэгдлийг ур чадвар гэж нэрлэдэг.

"Сэтгүүл зүйн практикт ур чадвар гэдэг сэтгүүлч хүний үйл ажиллагааны шалгуур болдог ба түүнийг ажлын үнэлэмжийн гол үзүүлэлт"¹ болгодог. Сэтгүүлчийн ур чадвар болон түүний бүтээлд хамаардаггүй элемент гэж байдаггүй. Тэдний дотроос баримт сонголт, гарчиг, зохиомж, бичлэгийн төрөл зүйл гэсэн дөрвөн элемент онцгой үүрэг гүйцэтгэдэг.

Баримт сонголт бол аливаа нийтлэлийн хувьд үндэс суурь нь байдаг. Сэтгүүлч баримтыг тоочин бичих биш, харин сэтгүүлчийн эргэн тойронд байгаа баримтаас хамгийн гол баримтыг олж авах чадвартай байх ёстой. Энэ нь сэтгүүлчийн ур чадварын нэг илрэл юм. Гарчиг гэдэг бол доктор Ч.Чойсамбын тэмдэглэсэнээр "тухайн нийтлэлийн гол утга санааг агуулсан уншигчдыг өөртөө татах, цаашид унших сонирхлыг нь төрүүлдэг чухал

зүйл"² болдог. Тиймээс сайн гарчиг ур чадварын салшгүй хэсэг болдог онцлогтой юм.

Сэтгүүлч нийтлэлийнхээ бүтцийг тодорхой гаргаж, логик дэс дараатай, хоорондын уялдаа холбоо сайтай бичих нь агуулгад нөлөөлөх гол хүчин зүйл болдог. Тиймээс зохиомжгүйгээр ур чадварыг төсөөлөх боломжгүй. Сэтгүүлчийн уран бүтээлд бичлэгийн төрөл, зүйл хэмээх ойлголт онцгой байр эзэлдэг. Сэтгүүлч баримт сонгох,

боловсруулах чадвараас гадна бичлэгийн төрөл, зүйлүүдийг онол арга зүйн үүднээс зайлшгүй эзэмшсэн байх ёстой. Учир нь олж авсан мэдээллийг тодорхой нэг хэлбэрт оруулна гэдэг бол сэтгүүлчийн ур чадварын гол шалгуур, илэрхийлэл нь байдаг. Өөрөөр хэл-

бэл, уншигч нийтлэлийг уншихдаа ямар сэтгүүлч бичсэн байна вэ? гэдгийг тодорхойлохын тулд сонгож авсан баримтыг ямар хэлбэрт оруулж, ямар төвшинд боловсруулсан байгаагаар нь таньж мэддэг. Тийм учраас, ямар бичлэгийн төрөл, зүйлд оруулж яаж бичсэн бэ гэдэг нь сэтгүүлчийн ур чадварын үндсэн шалгуур нь болдог. Дээрх дөрвөн зүйлийг сэтгүүлч ур чадварын өндөр төвшинд боловсруулж чадвал сайн сэтгүүлч болох боломжийг хангаж байна гэсэн үг юм. Сэтгүүлч хүн байнга суралцаж, өөрийгөө туршиж шалгаж байж ур чадвараа дээшлүүлдэг. Тийм учраас сэтгүүлч бичлэгийн бүх төрөл, зүйлээр бичиж өөрийгөө

«

***Явцуу утгаараа ур чадвар гэдэг
сонгосон сэдвийг сэтгүүл зүйн
онол, практик, арга зүйн бүх
шалгууруудад нийцүүлэн агуулга
хэлбэрийн өндөр түвшинд
бүтээх үйл ажиллагаа мөн.
Тиймээс ч агуулга хэлбэрийн
нэгдлийг ур чадвар гэж нэрлэдэг.***

»

туршиж байх шаардлагатай гэж үздэг. Сэтгүүлчийн ур чадвар нь бичлэгийн төрөл, зүйл хэмээх ойлголттой салшгүй холбоотой байдаг учир ур чадварт гарсан өөрчлөлтийг юуны өмнө бичлэгийн төрөл, зүйлийн жишээн дээр авч үзэх нь чухал юм. Бичлэгийн төрөл, зүйлийг өргөн утгаар нь нийтлэл, нэвтрүүлгийн хэлбэр гэж авч үздэг. Бичлэгийн төрөл, зүйл нь ямагт агуулга хэлбэрийн нэгдэлийн илэрхийлэл байдаг. Тийм учраас ур чадварын шалгуурын үүргийг гүйцэтгэдэг.

1990 оноос хойш сэтгүүлчийн ур чадварт гарсан үндсэн өөрчлөлтийг бичлэгийн төрөл, зүйлтэй холбож тайлбарлахыг оролдье. Манай ахмад, туршлагатай сэтгүүлчид бараг бүх бичлэгийн төрөл, зүйлээр бичдэг байсан. Харин өнөөдөр ХМХ-д ажиллаж буй сэтгүүлчид мэдээ, ярилцлага, сурвалжлага, өгүүлэл гэсэн тоотой хэдэн бичлэгийн төрөл, зүйлээр бичиж амиа зогоож байна. Өөрөөр хэлбэл, сэтгүүл зүйн бичлэгийн төрлүүд эрс багассан гэж хэлж болно.

Өнөөдөр ХМХ-д мэдээний эзлэх байр суурь асар их болжээ. Хүн төрөлхтөн мэдээллийн эрэн зуунд амьдарч байгаа учир тэдний амьдралд түүний гүйцэтгэх үүрэг ч нэмэгдэж байна. Хэдий сэтгүүлчид мэдээг их бичиж байгаа ч тэдэнд дутагдал ажиглагдсаар байна. Үүнд:

- Сэтгүүлчид "уруугаа харсан пирамид" бүтцийг мэдээ бичихдээ ашиглаж чадахгүй байна. Энэ бол чухал зүйлийг хамгийн эхэнд дараа нь мэдээлэх зүйлийн ач холбогдол буурахын хэрээр дараалуулан бичиж чадахгүй байна гэсэн үг. Сэтгүүл зүйн мэдээний үнэн бодитой, товч тодорхой, энгийн ойлгомжтой байх зарчмыг

баримталж чадахгүй байна. Тийм учраас бичсэн мэдээ нь урт, сунжруу, уйтгартай болдог.

- Шар сонинд ажиллаж байгаа сэтгүүлчид сенсаац дэгдээсэн, хэн нэгний хувийн хэрэгт хэтэрхий гүнзгий орсон, үнэн эсэх нь мэдэгдэхгүй баримт сэлтийг ашиглан уйтгартай, сонины зайг бөглөх зорилгоор сунжирсан мэдээг бичиж байна.

- Зарим сэтгүүлчид мэдээнд орж байгаа баримтаа үнэн эсэхийг нь шалгалгүй бичсэний улмаас шүүхэд дуудагдах нь их болсон зэрэг нь үүний тод жишээ юм.

Өнөөдөр радио телевизийн мэдээллийн хөтөлбөрийн дийлэнх хэсэг нь сурвалжлагаас бүрдэж байна. Тиймээс мэдээллийн хөтөлбөрийг сурвалжлагагүйгээр төсөөлөхийн аргагүй болж. Сүүлийн үед аль ч ХМХ-д мэдээлсэн, үйл явдлын сурвалжлага түлхүү гарах болсон байна. Гэвч сурвалжлага нь нэлээд цаг хугацаа шаарддаг бичлэгийн зүйл учир сэтгүүлчид төдийлөн идэвхтэй байдлаар бичиж чадахгүй байна. Сэтгүүлчид үйл явдалд идэвхтэй оролцож гэрч болох үүрэг нь багасч, ихэвчлэн үйл явдлыг хөндлөнгөөс ажигласан, өөрийн бодол санаагаар бичих нь голлох болжээ. Энд ажиглагдаж буй өөр нэг дутагдал бол сэдвийн хувьд хэт явцуурсан байдал юм. Ихэвчлэн УИХ-ын тухай, дарга нарын хөдөө гадаа явсан айлчлал гэх мэт улс төрийн сэдэв рүү хэт туйлширч байгаа нь энэ бичлэгийн зүйлийн чанарт сөрөг нөлөө үзүүлж байна.

Сүүлийн үед ХМХ-д тодорхой байр суурийг эзэлж буй бичлэгийн зүйл бол ярилцлага юм. Ярилцлага нь сонины нэг дугаарт хэд хэдээр

нийтлэгдэх, радио телевизийн хөтөлбөрт шууд болон бусад хэлбэрийн ярилцлагууд олноор хийгдэх болсон. Энэ нь ярилцлага хэмээх бичлэгийн зүйл хүчтэй газар авч байгаагийн илрэл боловч, энэ төрөл, зүйлд тавигдах шаардлагыг тэр бүр хангахгүй байна. Ярилцлагын дотоод хэлбэрүүд ч баяжих хандлага ажиглагдах болсон. Түүний хамрах хүрээ нь харьцангуй өөрчлөгдөж байна. Ерээд оноос өмнө ярилцлагыг хязгаарлагдмал асуудлын

хүрээнд хийдэг байсан бол өнөөдөр сэтгүүлчид нийгмийн аль ч хүрээ салбарын хүмүүстэй ярилцаж, мэдээлэл авч байна. Урьд нь албан ёсны шинжтэй ярилцлагууд зонхилж байсан бол орчин үед чөлөөтэй хэв маяг руу тэмүүлэх болжээ. Өмнө нь ярилцлагыг хэдхэн албан тушаалтан, тоотой

хэдэн хүмүүсийн хүрээнд хийдэг байсан. Өнөө үед энэ байдал харьцангуй дэвшил гарч сэтгүүлчид өөрсдөө чөлөөтэй бичиж, ярилцлага авахыг хүссэн хүнээсээ өөрийн дуртай хэлбэрээр ярилцлага авч байна. Гэвч сүүлийн үед тогтмол хэвлэлд нийтлэгдэж буй ярилцлагын сэдэв давхцаж, ярилцлага өгч байгаа хүмүүсийн тоо ердөө тодохой хүрээнд эргэлдэж байна гэсэн тоо гарчээ. Зарим нэг туршлагатай сэтгүүлчид чөлөөтэй бичиж, шинийг эрэлхийлж байгаагийн үр дүнд ярилцлагын зарим дотоод хэлбэрүүд хөгжиж байна. Тухайлбал:

өөрөө өөртэйгээ хийсэн, эчнээ, хөрөг ярилцлага, ярилцлага эрэгцүүлэл зэргийг хэлж болно.

Нөгөө талаас сүүлийн үеийн сэтгүүлчид ярилцлагыг зөвхөн асуулт хариултаас бүрддэг амар хялбар бичлэгийн зүйл гэж үзсэнээс болж ярилцлага хэт олшрох хандлагатай байна. Ингэж ярилцлагын тоо хэмжээ олшрохын хэрээр түүний чанар муудаж, сонирхолгүй, уншуургүй, сонины зай бөглөсөн ярилцлага гарч

байна. Мөн нэг хэв загварт баригдсан, зохиомж нь муу ярилцлага их гарч байна. Энэ бол сэтгүүлчийн ур чадвар сул, бүтээлч эрэл хайгуул хийхгүй байгаагийн шалтгаан юм. Тийм учраас сэтгүүлчид аль болох сонирхол татсан, шинэ сэргэг асуудлаар сонирхолтой ярилцлага хийх хэрэгтэй байна.

«

Ерээд оноос өмнө ярилцлагыг хязгаарлагдмал асуудлын хүрээнд хийдэг байсан бол өнөөдөр сэтгүүлчид нийгмийн аль ч хүрээ салбарын хүмүүстэй ярилцаж, мэдээлэл авч байна. Урьд нь албан ёсны шинжтэй ярилцлагууд зонхилж байсан бол орчин үед чөлөөтэй хэв маяг руу тэмүүлэх болжээ.

»

Өгүүлэл нь анх сонин хэвлэл үүссэн цагаас эхлэн гол бичлэгийн төрөл байсаар ирсэн билээ. Өнөөдөр өгүүллийн дотоод хэлбэр урьд үеэ бодвол харьцангуй баяжиж, хөгжиж байна. Түүний дотроос сурталчилгааны, асуудал дэвшүүлсэн, шүүмжлэлт өгүүлэл тогтмол хэвлэлд түлхүү бичигдэх болж. Мөн онолын, тайлбар өгүүллүүд мэр сэр нийтлэгдэж байна. Урьд хэтэрхий магтсан, үнэнийг хэлж чаддаггүй байсан бол өнөөдөр дутагдал доголдлыг шүүмжилж харьцангуй чөлөөтэй бичдэг болж. Гэхдээ манай тогтмол хэвлэлд хэн нэгнийг хэт

шүүмжилсэн, эсвэл тэнгэрт тултал магсан өнгө аястай өгүүллүүд орсоор л байгаа нь энэ төрөл зүйлд ажиглагдаж байгаа гол дутагдлын нэг юм. Өгүүллийг түлхүү бичиж байгаа цөөхөн сонины нэг бол "Өдрийн сонин". Энэ сонины өгүүлэл нь улс төрийн бичлэгийн төрөл болсон гэж хэлэхэд болмоор байна. Учир нь хэн нэгэн улс төрч нам хүчнийг магтан дуулсан, эсвэл муулсан, дайрч давшилсан улс төрийн тогоон дахь бүхий л асуудлыг бичиж байгаа нь үүний тод илрэл юм. Дээр хэлсэн санаануудыг нэгтгэж дараах дүгнэлтийг хийж болох байна. Манай сэтгүүлчийн ур чадвар 1990 оноос өмнөхийг бодвол муудаж байгаа бөгөөд энэ нь хэд хэдэн хүчин зүйлтэй холбоотой юм. Үүнд:

1. 1990 оноос хойш манай улсад чанаргүй боловсон хүчин их бэлтгэгдэж байна. Өмнө нь сэтгүүлчдийг ОХМУ-д, МУИС-д бэлтгэн гаргадаг байсан. Өнөөдөр улсын, хувийн сэтгүүлч бэлтгэдэг 21 сургууль үйл ажиллагаагаа явуулж байна. Хувийн их дээд сургуулиудын хувьд сэтгүүлч эзэмшсэн байх ёстой бүх төрлийн хичээлийг дутуу зааж байгаагийн улмаас дийлэнхдээ чанаргүй боловсон хүчин бэлтгэгдэж байна.

2. Өмнөх үеийг бодвол ХМХ-ийн тоо олширч байна. Гэвч ХМХ-ний тоо олширч байгаа хэдий ч чанарт өөрчлөлт гарахгүй байна. Энэ нь ХМХ-д мэргэжлийн бус хүмүүс маш их ажиллаж байгаатай холбоотой. Мөн чанаргүй боловсон хүчинтэй ч холбоотой юм.

3. Мөн улс төрийн орчин, нөхцөл байдалтай холбоотой гэдэг нь тодорхой юм. Өнөөдөр олон улс төрийн хүчин бий болж, түүнийхээ хэрээр

тогтмол хэвлэлийг улс төрчид, улс төрийн хүчнүүд өөрсдийн хэрэгсэл болгон ашиглаж байна. Улмаар сурвалжлага, өгүүлэл зэрэг нь сэтгүүл зүйн, мэргэжлийн шинж чанараа алдаж улс төрийн бичлэгийн төрөл болж байна.

4. Сэтгүүлчийн ур чадварт дээрх өөрчлөлт гарч байгаа нь нийгмийн тогтолцоо өөрчлөгдсөнтэй холбоотой. Социализмын үед сэтгүүлчид дээрээс өгсөн удирдлагын дагуу бараг бүх бичлэгийн төрөл зүйлээр бичиж, илүү хөдөлмөрч, бүтээлчээр ханддаг байсан бол өнөөдөр сэтгүүлчид хэдхэн төрөл зүйлийн хүрээнд эргэлдэж байна. Одоо цаг үеэ дагаад сэтгүүлчид нийтлэл-уран сайхны бичлэгийн төрлүүдээр бараг бичихгүй байна.

Ишлэл

¹ З у л ь к а ф и л ь М. 1998. Орчин үеийн сэтгүүл зүй. УБ. 208 дахь тал.

² Ч о й с а м б а Ч. 2000. Монгол сонины мэдээ. УБ. 129 дахь тал.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. А н д е р с е н Х., М е л л и т М. 2000. Нийтлэл, нэвтгүүлгийг яаж бэлтгэх вэ? УБ.
2. В о р о ш и л о в В. В. 2004. Журналистика. СПб.
3. З у л ь к а ф и л ь М. 1998. Орчин үеийн сэтгүүл зүй. УБ.
4. М е н ч е р М. 2003. Сэтгүүл зүйн бичлэгийн үндэс. УБ.
5. Н о р о в с ү р э н Л. 2005. Сонины бичлэгийн төрөл, зүйл. УБ.
6. Ч о й с а м б а Ч. 2001. Сонины мэдээллийн бичлэгийн төрөл. УБ.

7. Ч о й с а м б а Ч. 2000. Монгол сонин
мэдээ. УБ.

Резюме

В данной статье автор раскрывает сущность понятия "мастерство журналиста", определяет его в широком и узком смыслах.

Автор опираясь на примеры жанров периодической печати, особенности содержания и формы публикаций показывает некоторые изменения мастерства монгольских журналистов. На основе исследования мастерства журналистов автор выдвинула некоторые практические рекомендации, направленные на улучшение мастерства журналистов.